		Пиридоксин гидрохлоридВ6) 5%-1мл	Орхон БОЭТ	765,000	255	3,000	
		Калийн хлорид 7.5 %-100мл	Орхон БОЭТ	1,886,850	2,995	630	
		Никотины хүчил (Витамин РР) 1%-1мл	Орхон БОЭТ	765,000	255	3,000	
		Фуросемид 1%-2мл	Орхон БОЭТ	900,000	300	3,000	
		Гепарин 5000ед/1мл	Орхон БОЭТ	29,700,000	3,300	9,000	
		Диазепам 0.5%-2мл	Орхон БОЭТ	600,000	1,000	600	
88	ОРАБОЭТ/264/001	натри хлорид 0.9%-3000мл	Орхон БОЭТ	2,880,000	14,400	200	Айвико ХХК
89	ОРАБОЭТ/264/002	Метилпреднизолон 500мг	Орхон БОЭТ	2,025,000	40,500	50	Монгол фарм ХХК
90	ОРАБОЭТ/266/001	Цефотаксим 1гр	Орхон БОЭТ	12,588,000	1,049	12,000	Нахиа импекс ХХК
91	ОРАБОЭТ/268/001	Сүүний хүчил2000000000 CFU	Орхон БОЭТ	2,499,000	850	2,940	Монос трейд ХХК
92	ОРАБОЭТ/269/001	Гентамицин сульфат 80мг-2мл	Орхон БОЭТ	1,440,000	240	6,000	Цомбо ХХК
93	ОРАБОЭТ/270/001	Амин хүчлүүд 8.5%-250мл	Орхон БОЭТ	807,200	20,180	40	Лхоёр ХХК
94	ОРАБОЭТ/270/002	Аминокапроны хүчил5%-100мл	Орхон БОЭТ	688,850	2,995	230	Айвико ХХК
		Глюкоз 10%-100мл	Орхон БОЭТ	383,250	1,825	210	
95	ОРАБОЭТ/270/005	Ацетилсалицилийн хүчил100мг	Орхон БОЭТ	30,000	50	600	Монос трейд ХХК
		Темрийн шар оксид 100мг/2мл	Орхон БОЭТ	4,275,000	9,500	450	
		Атракурын безилат 10мг/мл-2.5мл	Орхон БОЭТ	3,702,000	6,170	600	
96	ОРАБОЭТ/270/007	Глицин + Цистеин + Чихэр өвс (Моноамоны гли)	Орхон БОЭТ	7,560,000	5,600	1,350	Нэкст Женерэйшн Хеалт ХХК
97	ОРАБОЭТ/270/008	Карбидопа + Леводопа25мг+250мг	Орхон БОЭТ	672,000	560	1,200	Монгол фарм ХХК
98	ОРАБОЭТ/271/001	Прокаин 0.25%-100мл	Орхон БОЭТ	1,060,500	2,525	420	Айвико хэлт кэйр ХХК
		Натрийн хлорид 0.9%-100мл	Орхон БОЭТ	8,550,000	1,425	6,000	
		Рингерийн уусмал 250мл	Орхон БОЭТ	9,686,250	3,075	3,150	
		Рингерийн уусмал 500мл	Орхон БОЭТ	1,207,500	4,025	300	
		Натрийн хлорид 0.9%-500мл	Орхон БОЭТ	9,025,000	1,805	5,000	
99	ОРАБОЭТ/271/003	Магнийн сульфат 25%-10мл	Орхон БОЭТ	3,726,000	621	6,000	Монос трейд ХХК
		Ципрофлоксацин 100мг-10мл	Орхон БОЭТ	297,000	1,980	150	
		Кальцийн глюконат 10%-10мл	Орхон БОЭТ	386,000	772	500	
		Аминофиллин 24мг/мл-10мл	Орхон БОЭТ	792,000	528	1,500	
100	ОРАБОЭТ/271/005	Л-Орнитин Л-аспартат 10мл	Орхон БОЭТ	4,200,000	5,600	750	Хайтан арвижих ХХК
101	ОРАБОЭТ/271/006	Цитиколин 500мг-4мл	Орхон БОЭТ	851,250	5,675	150	Энто ХХК
		Левовфлоксацин 5мг/мл-100мл	Орхон БОЭТ	4,074,000	6,790	600	
102	ОРАБОЭТ/271/007	Маннитолын гексанитрат 10%-250мл	Орхон БОЭТ	1,445,850	4,590	315	Айвико ХХК
		Фентанил 50мкг/мл-2мл	Орхон БОЭТ	3,400,000	1,700	2,000	
103	ОРАБОЭТ/271/008	Метформин + Гликлазид 500мг+80мг	Орхон БОЭТ	7,000,000	280	25,000	Ази фарм ХХК
104	ОРАБОЭТ/271/009	Пантопразол 40мг	Орхон БОЭТ	1,224,000	680	1,800	Мөнхийн тун ХХК
		Эх барихын иж бүрдэл	Орхон БОЭТ	10,260,000	22,800	450	
105	ОРАБОЭТ/271/010	Эхо гель 250 мл	Орхон БОЭТ	333,000	1,110	300	Биомед трейд ХХК
106	ОРАБОЭТ/272/001	Атенолол 50мг	Орхон БОЭТ	149,400	249	600	Орхон эм хангамж ХХК
		Карведилол 6.25мг	Орхон БОЭТ	241,000	482	500	
107	ОРАБОЭТ/272/002	Глюкоз 40%-10мл	Орхон БОЭТ	150,000	500	300	Монос трейд ХХК
		Цианакобаламин (Витамин В12) 500мкг/1мл	Орхон БОЭТ	260,000	260	1,000	
		Натрийн салицилат 10%-10мл	Орхон БОЭТ	205,500	685	300	
		Метформин 850мг	Орхон БОЭТ	1,717,200	265	6,480	
		Менадион натрийн бисульфит (Викасол) 1%-1м	Орхон БОЭТ	804,000	670	1,200	
		Цетиризин 10мг	Орхон БОЭТ	405,000	90	4,500	
108	ОРАБОЭТ/272/003	Декстроз 5%-100мл	Орхон БОЭТ	372,750	1,775	210	Айвико Хэлт Кэйр ХХК
109	ОРАБОЭТ/272/004	Тиамин хлорид (Витамин В1) 5%-1мл	Орхон БОЭТ	612,000	255	2,400	Айвико ХХК
		Дифенгидрамин (Димедрол) 1%-1мл	Орхон БОЭТ	2,295,000	255	9,000	
		Трамадол 5%-2мл	Орхон БОЭТ	1,320,000	1,100	1,200	
		Метронидазол 500мг-100мл	Орхон БОЭТ	2,528,750	1,445	1,750	
		Пиридоксин гидрохлоридВ6) 5%-1мл	Орхон БОЭТ	765,000	255	3,000	
		Никотины хүчил (Витамин РР) 1%-1мл	Орхон БОЭТ	765,000	255	3,000	
		Калийн хлорид 7.5%-100мл	Орхон БОЭТ	1,886,850	2,995	630	
		Морфин гидрохлорид 1%-1мл	Орхон БОЭТ	340,000	1,700	200	
		Натри хлорид 0.9%-250 мл	Орхон БОЭТ	20,737,500	1,975	10,500	
		Декстроз 5%-00мл	Орхон БОЭТ	387,900	2,155	180	
		Фуросемид 1%-2мл	Орхон БОЭТ	900,000	300	3,000	
110	ОРАБОЭТ/272/005	Инозин пранобекс 500мг	Орхон БОЭТ	156,000	780	200	Монфа трейд ХХК
		Цитиколин (Цераксон) 1000мг/4мл	Орхон БОЭТ	5,700,000	7,600	750	
111	ОРАБОЭТ/272/006	Калийн аспартат + Магнийн аспартат (Панангин)	Орхон БОЭТ	1,100,000	2,200	500	Еврофарм ХХК
		Кетопрофен 100мг-2мл	Орхон БОЭТ	5,011,200	2,088	2,400	
112	ОРАБОЭТ/272/007	Кетотифен 1мг	Орхон БОЭТ	1,350,000	300	4,500	Нахиа импекс ХХК
113	ОРАБОЭТ/272/008	Нэг удаагийн малгай	Орхон БОЭТ	2,100,000	210	10,000	Мөнхийн тун ХХК
		Хлорамфеникол 500мг	Орхон БОЭТ	140,000	350	400	
114	ОРАБОЭТ/272/009	Оланзагин 10мг	Орхон БОЭТ	940,800	1,400	672	Ази фарм ХХК
115	ОРАБОЭТ/273/001	Амоксициллин+клавуланы хүчил 1.2г	Орхон БОЭТ	13,580,000	6,790	2,000	Монгол фарм ХХК

116	ОРАБОЭТ/273/003	Диклофенак 100мг	Орхон БОЭТ	1,500,000	750	2,000	Еврофарм ХХК
		Диклофенак 75мг/мл-3мл	Орхон БОЭТ	4,080,000	680	6,000	
117	ОРАБОЭТ/276/001	Флуфеназин 25мг -1мл	Орхон БОЭТ	312,000	5,200	60	Монос трейд ХХК
118	ОРАБОЭТ/277/001	Азитромицин 500мг	Орхон БОЭТ	1,632,000	1,700	960	Монфа трейд ХХК
119	ОРАБОЭТ/278/001	Левеофлоксацин 5мг/мл-100мл	Орхон БОЭТ	1,500,000	7,500	200	Монгол фарм ХХК
120	ОРАБОЭТ/281/001	Морфин сульфат 1%-1мл	Орхон БОЭТ	3,400,000	1,700	2,000	Айвиго ХХК
121	ОРАБОЭТ/281/002	Пропофол 1%-20мл	Орхон БОЭТ	3,780,000	18,900	200	Их шүүдэргэнэ ХХК
122	ОРАБОЭТ/283/001	Ципрофлоксацин 100мг-10мл	Орхон БОЭТ	99,000	1,980	50	Монос трейд ХХК
123	ОРАБОЭТ/284/001	Сүүний хүчил2000000000 CFU	Орхон БОЭТ	1,237,600	1,456	850	Монос трейд ХХК
124	ОРАБОЭТ/285/001	Офлоксацин 2мг/мл-100мл	Орхон БОЭТ	544,800	1,816	300	Энхийн шүүдэр ХХК
125	ОРАБОЭТ/288/001	Хөвөн 50гр		1,152,000	1,440	800	Медиконт ХХК
126	ОРАБОЭТ/289/001	Галоперидол 5мг	Орхон БОЭТ	150,000	150	1,000	Ази фарм ХХК
127	ОРАБОЭТ/290/001	Натрийн хлорид 0.9%-500мл	Орхон БОЭТ	2,707,500	1,805	1,500	Айвиго хэлт кэйр ХХК
128	ОРАБОЭТ/291/001	Трамадол 5%-2мл	Орхон БОЭТ	5,400,000	1,500	3,600	Айвиго ХХК
		Морфин сульфат 1%-1мл	Орхон БОЭТ	3,400,000	1,700	2,000	
		Калийн хлорид 7.5 %-100мл	Орхон БОЭТ	1,886,850	2,995	630	
		Тиамин хлорид (Витамин В1) 5%-1мл	Орхон БОЭТ	1,176,000	490	2,400	
		Метронидазол 500мг-100мл	Орхон БОЭТ	8,741,250	1,665	5,250	
		Никотины хүчил (Витамин РР) 1%-1мл	Орхон БОЭТ	1,470,000	490	3,000	
		Фүросемид 1%-2мл	Орхон БОЭТ	1,335,000	445	3,000	
		Натри хлорид 0.9%-250мл	Орхон БОЭТ	26,160,000	2,180	12,000	
		Пиридоксин гидрохлоридВ6) 5%-1мл	Орхон БОЭТ	1,470,000	490	3,000	
		Декстроз 5%-500мл	Орхон БОЭТ	144,300	2,405	60	
		Декстроз 5%-250мл	Орхон БОЭТ	1,449,000	2,300	630	
129	ОРАБОЭТ/291/002	Натрийн салицилат 10%-10мл	Орхон БОЭТ	121,350	809	150	Тимус фарм ХХК
		Цианакобаламин (Витамин В12) 500мкг/1мл	Орхон БОЭТ	247,000	494	500	
		Менадион натрийн бисульфит (Викасол) 1%-1мл	Орхон БОЭТ	606,750	809	750	
130	ОРАБОЭТ/292/001	Амоксициллин+ клавуланы хүчил 500 мг+125 мг	Орхон БОЭТ	2,280,000	1,140	2,000	Дарвифарм ХХК
131	ОРАБОЭТ/292/002	Амоксициллин+клавуланы хүчил 1.2г	Орхон БОЭТ	13,400,000	6,700	2,000	Хайтан арвижих ХХК
132	ОРАБОЭТ/292/003	Ампициллин 1г	Орхон БОЭТ	4,530,000	755	6,000	Тимус фарм ХХК
		Ибупрофен 400мг	Орхон БОЭТ	500,000	250	2,000	
133	ОРАБОЭТ/292/004	Аскорбины хүчил 5%- 2мл	Орхон БОЭТ	11,880,000	660	18,000	Нахиа импекс ХХК
134	ОРАБОЭТ/292/005	Диклофенак 75мг/мл-3мл	Орхон БОЭТ	4,800,000	800	6,000	Айвиго ХХК
		Дифенгидрамин (Димедрол) 1%-1мл	Орхон БОЭТ	3,780,000	420	9,000	
		Диазепам 0.5%-2мл	Орхон БОЭТ	1,125,000	1,500	750	
		Метоклопрамид 50мг/мл -2мл	Орхон БОЭТ	3,120,000	1,040	3,000	
		Атракурын безилат 10мг/мл-2.5мл	Орхон БОЭТ	4,290,000	7,150	600	
		Гепарин 5000ед/1мл	Орхон БОЭТ	32,400,000	3,600	9,000	
135	ОРАБОЭТ/292/006	Хлорпромазин 100мг	Орхон БОЭТ	200,000	200	1,000	Ази фарм ХХК
		Литийн карбонат 300мг	Орхон БОЭТ	150,000	300	500	
136	ОРАБОЭТ/293/001	Рингериин уусмал 250мл	Орхон БОЭТ	12,915,000	3,075	4,200	Айвиго Хэлт Кэйр ХХК
		Прокаин 0.25%-100мл	Орхон БОЭТ	1,590,750	2,525	630	
		Рингериин уусмал 500мл	Орхон БОЭТ	1,207,500	4,025	300	
137	ОРАБОЭТ/293/002	Метформин + Гликлазид 500мг+80мг	Орхон БОЭТ	8,400,000	280	30,000	Ази фарм ХХК
		бАльбумин 20%-100мл	Орхон БОЭТ	12,408,000	206,800	60	
138	ОРАБОЭТ/293/003	Амин хүчлүүд 8.5%-250мл	Орхон БОЭТ	1,222,800	20,380	60	Лхоёр ХХК
139	ОРАБОЭТ/293/004	Глюкоз 10%-100мл	Орхон БОЭТ	1,149,750	1,825	630	Айвиго ХХК
		Аминокапроны хүчил5%-100мл	Орхон БОЭТ	628,950	2,995	210	
		Натри хлорид 0.9%-3000мл	Орхон БОЭТ	4,320,000	14,400	300	
		Маннитолын гексанитрат 10%-250мл	Орхон БОЭТ	1,445,850	4,590	315	
		Фентанил 50мкг/мл-2мл	Орхон БОЭТ	2,380,000	1,700	1,400	
140	ОРАБОЭТ/293/005	Магнийн сульфат 25%-10мл	Орхон БОЭТ	2,484,000	621	4,000	Монос трейд ХХК
		Төмрийн шар оксид 100мг/2мл	Орхон БОЭТ	4,275,000	9,500	450	
		Амлодипин+Валсартан 10мг+160мг	Орхон БОЭТ	2,772,000	1,650	1,680	
		Аминофиллин 24мг/мл-10мл	Орхон БОЭТ	855,360	528	1,620	
141	ОРАБОЭТ/293/006	Гентамицин сульфат 80мг-2мл	Орхон БОЭТ	1,350,000	225	6,000	Цомбо ХХК
142	ОРАБОЭТ/293/007	Дипиридабол 25мг	Орхон БОЭТ	122,400	170	720	Орхон эм хангамж ХХК
143	ОРАБОЭТ/293/008	Карбидопа + Леводопа25мг+250мг	Орхон БОЭТ	1,008,000	560	1,800	Монгол фарм ХХК
144	ОРАБОЭТ/293/009	Ондансетрон 8мг/4мл	Орхон БОЭТ	1,500,000	2,500	600	Хайтан арвижих ХХК
145	ОРАБОЭТ/293/010	Пропофол 1%-20мл	Орхон БОЭТ	11,340,000	18,900	600	Их шүүдэргэнэ ХХК
146	ОРАБОЭТ/293/011	Сальбутамол+Ипратропийн бромид2.5мг+500мг	Орхон БОЭТ	3,780,000	3,000	1,260	Чин баян трейдинг ХХК
147	ОРАБОЭТ/293/012	Флуконазол 50мг	Орхон БОЭТ	207,600	692	300	Мөнхийн тун ХХК
		Ципрофлоксацин 500мг	Орхон БОЭТ	72,000	240	300	
		Эх барихын иж бүрдэл	Орхон БОЭТ	10,260,000	22,800	450	
		Флуконазол 150мг	Орхон БОЭТ	2,580,000	4,300	600	
148	ОРАБОЭТ/293/013	Цефепим 1гр	Орхон БОЭТ	5,250,000	17,500	300	Палома ХХК
149	ОРАБОЭТ/293/014	Цефотаксим 1гр	Орхон БОЭТ	18,882,000	1,049	18,000	Нахиа импекс ХХК
150	ОРАБОЭТ/293/015	Цитиколин 500мг-4мл	Орхон БОЭТ	1,702,500	5,675	300	Мөнхийн тун ХХК
151	ОРАБОЭТ/294/001	Ванкомицин 1гр	Орхон БОЭТ	9,000,000	15,000	600	Энто ХХК
152	ОРАБОЭТ/294/002	Габалентин 300мг	Орхон БОЭТ	360,000	400	900	Монгол фарм ХХК
153	ОРАБОЭТ/294/003	Натрийн хлорид 0.9%-100мл	Орхон БОЭТ	24,750,000	4,125	6,000	Айвиго хэлт кэйр ХХК
		Декстроз 5%-100мл	Орхон БОЭТ	372,750	1,775	210	
		Натрийн хлорид 0.9%-500мл	Орхон БОЭТ	13,537,500	1,805	7,500	
		Лидокаин 2%-2мл	Орхон БОЭТ	492,000	205	2,400	
154	ОРАБОЭТ/294/004	Инозин пранобекс 500мг	Орхон БОЭТ	240,000	800	300	Монфа трейд ХХК
155	ОРАБОЭТ/294/005	Л-Орнитин Л-аспартат 10мл	Орхон БОЭТ	1,680,000	5,600	300	Хайтан арвижих ХХК
156	ОРАБОЭТ/294/006	Цетиризин 10мг	Орхон БОЭТ	270,000	90	3,000	Монос трейд ХХК
		Метформин 850мг	Орхон БОЭТ	1,717,200	265	6,480	

157	ОРАБОЭТ/295/001	Нэг удаагийн амны хаалт (Угладаг)	Орхон БОЭТ	2,520,000	210	12,000	Нахиа импекс ХХК
158	ОРАБОЭТ/296/001	Дамжуулагч гуурс /гуяны/ /4F-8F, 10-13cm/	Орхон БОЭТ	275,000	55,000	5	Медиконт ХХК
		3 хаалттай крант /3 хаалттай/	Орхон БОЭТ	880,000	44,000	20	
		Дамжуулагч гуурс /шууны/ /4F-6F, 7cm-11cm/	Орхон БОЭТ	1,140,000	57,000	20	
		Чиглүүлэгч 0.014, /титмийн/ /0,014, 180cm, J or	Орхон БОЭТ	1,980,000	198,000	10	
		Оношилгооны катетер /зүүн/ /JL4.0, 6F, 100cm/	Орхон БОЭТ	960,000	48,000	20	
		Энгийн тэлэгч баллоон /1.2x8mm-20mm*4.0x8mm/	Орхон БОЭТ	1,980,000	198,000	10	
		Төмөр чиглүүлэгч 0.035 инч /0.035", J tip, 150cm/	Орхон БОЭТ	780,000	39,000	20	
		Оношилгооны катетер /баруун/ /JR4.0, 6F, 100cm/	Орхон БОЭТ	960,000	48,000	20	
159	ОРАБОЭТ/297/001	Метформин 850мг	Орхон БОЭТ	1,621,800	265	6,120	Ази фарм ХХК
160	ОРАБОЭТ/298/001	Глицин + Цистеин + Чихэр өвс (Моноамоны глицин)	Орхон БОЭТ	5,112,000	5,680	900	Нэжст Женерэйшн Хeaлт ХХК
161	ОРАБОЭТ/299/002	Карведилол 6.25мг	Орхон БОЭТ	240,000	480	500	Ач-Үр ХХК
162	ОРАБОЭТ/302/001	Цефазолин 1г	Орхон БОЭТ	7800000	1,300	6,000	Нахиа импекс ХХК
163	ОРАБОЭТ/303/001	Кветиапиний фумарат 100мг	Орхон БОЭТ	1,350,000	1,500	900	Ази фарм ХХК
164	ОРАБОЭТ/304/001	Чиглүүлэгч гидрофиль 0.035 /0.035", J tip, 150cm/	Орхон БОЭТ	557,500	111,500	5	Медиконт ХХК
		Энгийн тэлэгч баллоон /1.2x8mm-20mm*4.0x8mm/	Орхон БОЭТ	4,800,000	240,000	20	
		Манометр /30 атм/	Орхон БОЭТ	1,625,000	65,000	25	
		Өндөр даралтын тэлэгч баллон /2.75x12mm-15mm/	Орхон БОЭТ	2,070,000	345,000	6	
		3 хаалттай крант /3 хаалттай/	Орхон БОЭТ	2,550,000	42,500	60	
		Чиглүүлэгч 0.014, /титмийн/ /0,014, 180cm, J or	Орхон БОЭТ	6,000,000	240,000	25	
165	ОРАБОЭТ/304/002	Дамжуулагч гуурс /шууны/ /4F-6F, 7cm-11cm/	Орхон БОЭТ	2,700,000	45,000	60	Чоногол трейд ХХК
		Эмчилгээний катетр /баруун/ /JR3.5, JR4.0, JR4.5, JR5.0/	Орхон БОЭТ	810,000	162,000	5	
		Оношилгооны катетер /зүүн/ /JL4.0, 6F, 100cm/	Орхон БОЭТ	3,450,000	57,500	60	
		Оношилгооны катетер /баруун/ /JR4.0, 6F, 100cm/	Орхон БОЭТ	3,360,000	56,000	60	
		Эмчилгээний катетер /EBU, XB/ /EBU3.5, 4.0, XBU3.5, 4.0, XBU4.0, 4.5, XBU5.0, 5.0/	Орхон БОЭТ	810,000	162,000	5	
		Дамжуулагч гуурс /гуяны/ /4F-8F, 10-13cm/	Орхон БОЭТ	225,000	45,000	5	
		Эмчилгээний катетр /зүүн/ /JL3.5, JL4.0, JL4.5, JL5.0/	Орхон БОЭТ	4,000,000	160,000	25	
		Төмөр чиглүүлэгч 0.035 инч /0.035", J tip, 150cm/	Орхон БОЭТ	2,700,000	45,000	60	
166	ОРАБОЭТ/305/001	Эхо гель 250 мл	Орхон БОЭТ	666,000	1,110	600	Биомед трейд ХХК
167	ОРАБОЭТ/309/001	Галоперидол 5мг	Орхон БОЭТ	300,000	150	2,000	Ази фарм ХХК
168	ОРАБОЭТ/309/002	Нэг удаагийн малгай	Орхон БОЭТ	2,000,000	250	8,000	Мөнхийн тун ХХК
169	ОРАБОЭТ/311/001	Оланзапин 10мг	Орхон БОЭТ	940,800	1,400	672	Ази фарм ХХК
170	ОРАБОЭТ/312/001	Кетопрофен 100мг-2мл	Орхон БОЭТ	2,088,000	2,088	1,000	Еврофарм ХХК
171	ОРАБОЭТ/312/002	Омепразол 20мг	Орхон БОЭТ	87,500	125	700	Торгон туул ХХК
172	ОРАБОЭТ/312/003	Сүүний хүчил20000000000 CFU	Орхон БОЭТ	1,547,000	850	1,820	Монос трейд ХХК
		Ципрофлоксацин 100мг-10мл	Орхон БОЭТ	198,000	1,980	100	
		Нийт дүн		1.333.501.219			

Боловсруулсан:

Эм зүйн тасгийн эрхлэгч Н.Амаржаргал

ЦАХИМ СИСТЕМЭЭР ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 9.1-д заасны дагуу худалдан авах ажиллагааг цахим систем (цаашид “цахим систем” гэх)-ээр зохион байгуулахтай холбоотой нөхцөл, шаардлагыг тодорхойлох, цахим системийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах, тендер шалгаруулалттай холбоотойгоор цахим системд хандах, мэдээлэл авах эрх бүхий этгээдийг тогтооход энэ журмын зорилго оршино.

1.2.Цахим систем нь www.tender.gov.mn гэсэн хаягтай байх ба цахим системийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “мэргэжлийн байгууллага” гэх) хангаж ажиллана.

1.3.Захиалагч, аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогч болон холбогдох бусад этгээд хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн байгууллагаас гаргасан журам, аргачлал, зааварчилгааны дагуу цахим системийг хэрэглэнэ.

Хоёр.Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах

2.1.Захиалагч Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу цахим системд бүртгэгдсэнээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулна.

2.2.Захиалагч тендер шалгаруулалтыг хуульд зааснаар зохион байгуулахад дараахыг баримтална. Үүнд:

2.2.1.үнэлгээний хороог цахим систем дэх худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны мэдээллийн санд бүртгэлтэй этгээдээс сонгож байгуулах;

2.2.2.үнэлгээний хороо байгуулсан шийдвэр, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг цахим системд бүртгэх;

2.2.3.үнэлгээний хороо тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, захиалагчаар батлуулсны дараа тендер шалгаруулалтын зарлал, урилга, тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим системд нийтлэх;

2.2.4.хуулийн 19.1-д заасны дагуу тодруулга авах хүсэлт сонирхогч этгээдээс гаргасан бол түүний нэрийг дурдалгүйгээр хүсэлтийг тодруулгын хамт албан

бичгээр цахим систем дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлж, тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлтийг захиалагчаар батлуулж нийтлэх;

2.2.5.үнэлгээний хороо захиалагчийн шийдвэр, тендертэй холбоотой тодруулгыг цахим системд бүрэн нийтэлснээр тендер шалгаруулалтын үр дүн нийтлэгдэх бөгөөд шалгарсан оролцогчийн тендерийн хүний эмзэг мэдээлэлд хамаарахгүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулгыг гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын таван өдрийн хугацаанд цахим системээр бусад оролцогчид ил болгох;

2.2.6.тендерийн нээлтэд зарласан үнийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан нөхцөлөөр үнийн задаргааны нийт нийлбэр дүнгээр өөрчилж тооцсон, эсхүл арифметик алдааг залруулсан залруулгыг оролцогч хүлээн зөвшөөрч хариу ирүүлсэн бол энэ тухай тэмдэглэл үйлдэж, тендерийн нээлтэд зарлагдсан цахим системийн мэдээллийг залруулах;

2.2.7.худалдан авах гэрээг цахим системд байршуулах ба хуульд зааснаар давуу эрх тооцсон, дотоодын үйлдвэрээс худалдан авах нөхцөлтэй гэрээний мэдээллийг цахим системд бүртгэх;

2.2.8.худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх.

2.3.Аж ахуй эрхлэгч Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу цахим системд бүртгэгдсэнээр тендер шалгаруулалтад дараах байдлаар оролцоно. Үүнд:

2.3.1.тендер шалгаруулалтад түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй оролцох бол холбогдох гэрээг цахим системээр баталгаажуулсан байх;

2.3.2.хуулийн 19.1-д заасны дагуу тодруулга авах хүсэлтийг тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гаргах;

2.3.3.тендерийн баталгаа шаардсан нөхцөлд хуулийн 22.7-д заасны дагуу тендерийн баталгааг цахим системээр дамжуулан хүргүүлэх;

2.3.4.Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу цахим системд баталгаажсан чадавх, туршлагыг нотлох мэдээлэл, баримт бичгээс шаардлагатайг сонгож, тендерийн хамт илгээх;

2.3.5.хуулийн 15.2, энэ журмын 2.3.4-т заасанд хамаарахгүй оролцогчийн ерөнхий шаардлага, чадавх, туршлагыг нотлох баримтыг “PDF” форматаар гаргацтай, тод хөрвүүлэх;

2.3.6.энэ журмын 2.3.5-д заасан нотлох баримт, тендерийн үнэ, тендерийн хүчинтэй байх хугацаа, санал болгосон үнийн хөнгөлөлт болон холбогдох бусад мэдээллийг цахим системийн холбогдох талбарт бүрэн оруулж,

мэргэжлийн байгууллагын гаргасан зааварчилгааны дагуу тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх;

2.3.7.цахим системд тендер илгээхэд хуулийн этгээд бол түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн, эсхүл түүнийг итгэмжлэлээр төлөөлөх этгээдийн, иргэн бол тухайн иргэний тоон гарын үсгээр баталгаажуулах;

2.3.8.цахим системээр тендер илгээхэд үйлчилгээний хураамж төлөх;

2.3.9.шаардлагатай гэж үзвэл тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендертээ нэмэлт, өөрчлөлт оруулах.

2.4.Тендер шалгаруулалтын зарлал, урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.

2.5.Захиалагч цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараах журмаар ирүүлсэн тендер шалгаруулалт зарласнаас хойших мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгоно. Үүнд:

2.5.1.татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт. Уг тодорхойлолтыг оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим системээр дамжуулан авч цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбосон байх;

2.5.2.шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөртэй эсэх тодорхойлолт. Уг тодорхойлолтыг оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим системээр дамжуулан авч цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбосон байх;

2.5.3.хуульд заасан эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл (энгийн болон тусгай)-ийн мэдээлэл, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, дээд боловсролын дипломын мэдээлэл, санхүүгийн тайлан зэрэг бодит цагийн горимоор дамжуулдаг, өдөр тутам өөрчлөгддөггүй мэдээлэл.

2.6.Энэ журмын 2.5 дахь заалт хуулийн 4.1.6-д заасан гадаадын этгээдийн ирүүлсэн тендерт хамаарахгүй.

2.7.Захиалагч энэ журмын 2.2.4-т заасны дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулснаас бусад үндэслэлээр тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах бол энэ тухай цахим систем дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлж, тендер шалгаруулалтын баримт бичигт холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгана.

2.8.Захиалагчийн цахим системд оруулсан мэдэгдлийн талаар зурвасыг цахим системд бүртгүүлсэн аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогчийн бүртгэлтэй цахим шуудангийн хаягаар, эсхүл гар утасны зурвас болон харилцаа холбооны бусад хэлбэрээр илгээж мэдэгдэх ба аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогч тухайн цахим шууданг ашиглаж байгаа эсэхээс үл хамааран хүлээн авсанд тооцно.

2.9.Захиалагчийн шийдвэр, тендер шалгаруулалтын үр дүнг энэ журмын 2.2.5-д заасны дагуу цахим системээр оролцогчид нэгэн зэрэг мэдэгдсэн өдрөөс эхлэн хуулийн 30.1-д заасан гэрээг байгуулах хугацааг тоолно.

2.10.Захиалагч болон аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогчоос ажлын цаг дууссаны дараа, эсхүл амралтын өдөр цахим системд оруулсан баримт бичгийг холбогдох этгээд дараагийн ажлын өдөр хүлээн авсанд тооцно.

2.11.Оролцогч энэ журмын 2.3.1-д зааснаар гэрээг баталгаажуулаагүй бол түншлэл, эсхүл туслан гүйцэтгүүлэх гэрээ бүхий тендер ирүүлсэн оролцогч гэж үзэхгүй.

2.12.Оролцогчоос ирүүлсэн тендер энэ журмын 2.3.5-д заасан шаардлага хангаагүй бол тухайн баримт бичгийг үнэлгээнд харгалзан үзэхгүй.

2.13.Оролцогчоос ирүүлсэн тендер энэ журмын 2.3.6-д заасны дагуу цахим системийн холбогдох талбарт оруулсан мэдээлэлтэй зөрвөл цахим системийн мэдээллийг баримтална.

2.14.Тендерийг энэ журмын 2.3.7-д заасан этгээдээс өөр этгээдийн тоон гарын үсгээр баталгаажуулан цахим системд ирүүлснээс үл хамаарч тухайн аж ахуй эрхлэгчийг тендер шалгаруулалтад оролцсон гэж тооцно.

2.15.Хуулийн 22.7-д зааснаар тендерийн баталгааг цахим системээр дамжуулан ирүүлээгүй тендерийг нээхээс татгалзана.

Гурав.Мэргэжлийн байгууллагын чиг үүрэг

3.1.Мэргэжлийн байгууллага Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д зааснаар цахим системийн мэдээлэл хариуцагч байх ба тус хуульд заасан үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.Мэргэжлийн байгууллага хуулийн 49.4-т зааснаас гадна цахим системтэй холбоотой дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1.цахим систем болон түүний бүрэлдэхүүн хэсгийн портал хуудсыг хөтлөх, бүртгэлийн тогтолцоог ханган ажиллах, цахим системийн хэвийн үйл ажиллагааг хариуцах;

3.2.2.баталгаа гаргагч, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч, бусад төрийн байгууллага, тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэгч байгууллага болон бусад шаардлагатай байгууллагатай гэрээ байгуулж ажиллах;

3.2.3.энэ журмын 3.2.2-т заасны дагуу байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянаж, хангаж ажиллах;

3.2.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гомдол хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага, хууль, хяналтын байгууллагыг тухайн хяналт, шалгалтын хүрээнд хяналт тавих боломжоор хангах, байгууллагын хүсэлтэд үндэслэн цахим системд нэвтрэх эрх олгох;

3.2.5.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112.10-т зааснаар цахим системд байршуулсан баримт бичгийг шинжлэн судлах хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүсэлт, эсхүл захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн шүүгчийн захирамжид үндэслэн тухайн тендер шалгаруулалтын дугаар, зарлал, урилгын мэдээллийн дагуу цахим системд нэвтрэх эрх олгох;

3.2.6.тендер шалгаруулалттай холбоотойгоор цахим системд захиалагчаас оруулж буй мэдэгдэл, нэмэлт мэдээлэл, тодруулга, тендер шалгаруулалтын баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлт, гомдол хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдээллийг оролцогчид цахим шуудан, эсхүл гар утасны зурвас болон харилцаа холбооны бусад хэлбэрээр дамжуулан хүргэх техникийн шийдлийг бий болгон ажиллах;

3.2.7.тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх, лавлагаа тодорхойлолт зэрэг нийтийн мэдээлэл солилцохоор гэрээ байгуулсан байгууллагуудыг цахим системд нэвтэрч, холбогдох мэдээллийг нийтлэх боломжоор хангах;

3.2.8.цахим системээр зохион байгуулж буй тендер шалгаруулалт, түүнд нийтлэгдэж буй мэдээлэлд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, хяналт тавих, илэрсэн алдаа, дутагдлыг арилгуулах тухай холбогдох байгууллагуудад шаардлага, мэдээлэл, зөвлөгөө хүргүүлэх;

3.2.9.захиалагч, аж ахуй эрхлэгч цахим системийн үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөөгүй бол мэргэжлийн байгууллага үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй;

3.2.10.цахим системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагаа, сургалт, сурталчилгаа, нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллахтай холбогдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран цаг үеийн асуудлаар улирал тутам уулзалт зохион байгуулах;

3.2.11.цахим систем төрийн бусад системтэй харилцан өгөгдөл солилцох боломжтой бөгөөд үйл ажиллагааны дарааллын дагуу цахим системд оруулсан нэг төрлийн өгөгдөл бусад системд харилцан солилцох боломжтой байх системийн хөгжүүлэлт хийх.

3.3.Мэргэжлийн байгууллага хуулийн 8.2-т заасан жагсаалтад орсон барааг ерөнхий гэрээний аргын дагуу сонгон шалгаруулж, цахим дэлгүүрт байршуулан, тухайн барааг шууд худалдан авах боломжоор захиалагчийг хангаж болно.

Дөрөв.Аж ахуй эрхлэгчийн чиг үүрэг

4.1.Аж ахуй эрхлэгч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 35.2-т заасан үүргийг хүлээнэ.

4.2.Аж ахуй эрхлэгч цахим системд нэвтрэх эрх авсан ажилтны үйлдэл, эс үйлдэл, түүнд олгогдсон эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой хариуцлагыг хүлээнэ.

4.3.Аж ахуй эрхлэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарах аливаа хариуцлагыг аж ахуй эрхлэгч өөрөө хариуцна.

4.4.Аж ахуй эрхлэгч, түүнийг төлөөлөн цахим системд нэвтрэх эрх бүхий этгээд цахим системд нэвтрэх эрх, нууц үгийн нууцлалыг хадгалах ба нууцлалыг алдсан, мартсан тохиолдолд цахим системээр мэргэжлийн байгууллагад хүсэлт гаргаж, цахим шуудангаар хариуг хүлээж авна.

4.5.Аж ахуй эрхлэгч холбогдох цахим системээс дамжуулан авч буй өөрийн тендерт холбоотой мэдээлэл, өөрийн ирүүлсэн тендер, түүнд хавсаргасан аливаа баримт бичгийн үнэн зөв эсэхийг нягтлах, алдаатай тохиолдолд тендер хүлээж авах эцсийн хугацаанаас өмнө залруулах үүрэгтэй ба энэ үүргээ биелүүлээгүйтэй холбоотой хариуцлагыг дангаар хүлээнэ.

4.6.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

4.7.Оролцогч байгуулсан гэрээний гүйцэтгэлийн талаарх мэдээллийг нотлох баримтын хамт бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн хуваарийн дагуу цахим системд бүртгэнэ.

4.8.Энэ журмын 2.2.5-д заасны дагуу шалгарсан оролцогчийн тендерийн хүний эмзэг мэдээлэлд хамаарахгүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулгатай танилцах бусад оролцогч нууц хадгалах тухай баталгааг цахим хэлбэрээр гаргана. Захиалагч шаардлагатай гэж үзсэн бол бичгээр гаргуулж болно.

4.9.Аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалтад оролцох сонирхол илэрхийлэх болон оролцоход хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлнө.

4.10.Хуулийн 22.7-д зааснаар тендер илгэхээс өмнө тендерийн баталгааг цахим системээр дамжуулан хүргүүлэхтэй холбоотой үүрэг, хариуцлагыг аж ахуй эрхлэгч хүлээнэ.

Тав.Захиалагчийн чиг үүрэг

5.1.Захиалагч хуулийн 48.4.9-д зааснаас бусад баримт бичгийг тендер шалгаруулалт зохион байгуулж дууссанаар, хуулийн 48.4.9-д заасан баримт бичгийг гэрээг дүгнэж бараа, ажил, үйлчилгээг хүлээн авснаар зохих журмын дагуу архивлан хадгална.

5.2.Хуулийн 48.4-т заасан тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хамаарах баримт бичгээс цахим хэлбэрээр үйлдсэн баримт бичгийг цахим хэлбэрээр тусгай тээгч (зөөврийн хатуу диск, оптик диск) дээр архивлан хадгална.

5.3.Оролцогч үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлтэй танилцах хүсэлт гаргасан тохиолдолд хуулийн 29.3-т зааснаар танилцуулна.

5.4.Захиалагч үнэлгээний хорооны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан дэвшилтэт технологи, программ хангамж ашиглаж болно.

5.5.Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч цахим системд байршуулна.

5.6.Гэрээний гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсэгт шаардлагатай гэж үзвэл үнэлгээний хорооны гишүүнийг байлцуулж болно.

5.7.Энэ журмын 5.5-д зааснаар байршуулсан гэрээг шүүх хууль бус гэж тогтоосон, эсхүл талууд гэрээ цуцалсан, гэрээнээс татгалзсан бол захиалагч холбогдох мэдээллийг тухай бүр цахим системд шинэчилнэ.

5.8.Захиалагч ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээг худалдан авахад тухай бүр захиалгын хуудас цахим системд илгээнэ.

5.9.Цахим дэлгүүрээс худалдан авах нэг удаагийн захиалгын хуудаст тусгагдах худалдан авалтын хэмжээ тухайн төсвийн жилд цахим дэлгүүрээс худалдан авах нийт бараа, үйлчилгээний төсвийн 50 хувиас хэтрэхгүй байна.

5.10.Тухайн төсвийн жилд цахим дэлгүүрээс нэг бараа, үйлчилгээг нэг удаа худалдан авахаар төлөвлөсөн бол энэ журмын 5.8-д заасныг баримтлахгүй.

5.11.Энэ журмын 3.3-т зааснаар цахим дэлгүүрт байршсан барааг худалдан авах захиалгын нийт дүн 20,000,00.0 (хорин сая) төгрөгөөс ихгүй байна.

5.12.Цахим системээр зохион байгуулаагүй тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчийн тендерийн эмзэг мэдээлэлд хамаарахгүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулга, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлтэй танилцах бусад оролцогч бичгээр захиалагчид хүсэлт гаргаж, нууц хадгалах тухай баталгааг бичгээр гаргана. Захиалагч хүсэлтийн дагуу хуулбар хувийг танилцуулж, холбогдох баримт бичигтэй танилцсан оролцогчийн тухай тэмдэглэл үйлдэж, гарын үсгээр баталгаажуулан тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хадгална.

Зургаа.Цахим системийн аюулгүй ажиллагаа

6.1.Цахим системийн үйл ажиллагаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

6.2.Мэргэжлийн байгууллага цахим систем, түүний аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг хангуулах дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

6.2.1.цахим систем нь төрөөс баримтлах харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэл, мэдээллийн аюулгүй байдлын стандартад нийцсэн байх;

6.2.2.цахим системийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор цахим системд байнгын хяналт тавих;

6.2.3.худалдан авах ажиллагааны хууль, журамд нийцүүлэн цахим системийн үйл ажиллагааны шинэчлэл, сайжруулалтыг тасралтгүй хийх;

6.2.4.цахим системд мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хоёр жил тутамд хийлгэх;

6.2.5.цахим системийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг ханган ажиллахдаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр танилцуулж, холбогдох саналыг хэрэгжүүлж ажиллах;

6.2.6.системийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хоёр дэд бүтцэд суурилсан үндсэн, эсхүл үүлэн технологид суурилсан нөөц сервер тоног төхөөрөмжтэй байх.

6.3.Мэргэжлийн байгууллага цахим системийн ашиглалт, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дотоод журмыг баталж, хэрэгжүүлж болно.

Долоо.Бусад зүйл

7.1.Хуульд заасан гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн талаар мэдээллийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д зааснаар цахим системээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

7.2.Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас цахим систем ажиллах боломжгүйгээс шалтгаалан сонирхогч этгээд тендер шалгаруулалтад оролцох боломжгүй болсноос үүдэн гарах аливаа хариуцлагыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн байгууллага, захиалагч хариуцахгүй.

7.3.Энэ журмын 7.2-д зааснаар цахим систем ажиллах боломжгүй болсон тохиолдолд мэргэжлийн байгууллага энэ тухай захиалагчид нэн даруй мэдэгдэж, тендерийн нээлтийг тодорхой хугацаагаар хойшлуулж, энэ тухай цахим системээр дамжуулан, боломжгүй бол харилцаа холбооны бусад хэрэгслээр нэгэн зэрэг мэдэгдэнэ.

7.4.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---